Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

МОНГОЛДОО ХАРИУЦЛАГАТАЙГААР ОЛБОРЛОВ

Бичил уурхайгаар олборлосон алт болон түүнийг дагалдсан үнэт металлын шударга олборлолтын стандарт

ШУДАРГА ОЛБОРЛОЛТЫН САНААЧИЛГА

Колумб Улсад төвтэй Хариуцлагатай уул уурхайн холбоо (ХУУХ) нь бичил уурхайгаар олборлосон алтны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шударга олборлолтын (ШО) стандартыг боловсруулсан юм. ШО-ын стандарт нь:

- Бичил уурхайчдыг хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагаа эрхлэх боломжоор хангадаг.
- Бичил уурхайчдад нийгэм, байгаль орчин, хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулах, сайн засаглалыг бэхжүүлэх, экосистемийг нөхөн сэргээхэд нь сэдэлжүүлэх түлхэц болдог.
- Урамшууллын системээр дамжуулан бичил уурхайчдад илүү орлого олох боломж олгодог.
- Гуравдагч талын аудитын хяналтаар баталгааждаг гэрчилгээжүүлэлтийн систем юм.

Энэ стандартыг бичил уурхайчид хамт олноороо дагаж мөрдсөнөөр Шударга олборлолтын алт үйлдвэрлэх гэрчилгээ авч үйлдвэрлэсэн алтаа олон улсын зах зээлийн үнээр худалдах боломжтой болохоос гадна хариуцлагатай, ёс журамтай үйл ажиллагаа явуулсныхаа төлөө нэмэлт урамшуулал авч өөрсдийн орон нутгийн болон нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бодит хувь нэмэр оруулах таатай боломжийг бүрдүүлдэг юм.

Бичил уурхайгаар олборлосон алт болон түүний дагалдах үнэт металлын шударга олборлолт, худалдааны стандарт нь бичил уурхайчдын ажлын нөхцөл, технологи, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, жендер болон хүүхдийн хөдөлмөр, химийн бодисын менежмент, нийгмийн болон байгаль орчны хариуцлагатай холбоотой асуудлуудыг тусгасан бөгөөд дараах хоёр хэсгээс бүрддэг юм.

1. АЛТНЫ БИЧИЛ УУРХАЙН СТАНДАРТ:

- **Ерөнхий шаардлага ба заавар:** Хариуцлагатай бичил уурхайн стандарт, хэтийн зорилго ба зарчим, цар хүрээ, стандартын бүтэц, ашигласан материал, нэр томьёоны тодорхойлолт, хэрэгжүүлэлт, хүсэлт гаргах, хяналт тавих ба стандартад өөрчлөлт оруулах тухай тусгасан байна.
- **Нийгмийн хөгжил:** Бичил уурхайчдын байгууллагын гишүүд нь олон нийтэд тулгуурласан бичил уурхайчид байх, ШО-ын систем нь олон нийтийн хөгжлийг дэмжих, ардчилал, оролцоо ба ил тод байдлыг бүрдүүлж ажиллах, ялгаварлан гадуурхах үзэл гаргахгүй байх зэрэг асуудлуудыг тусгасан байна.
- **Эдийн засгийн хөгжил:** ШО-ын системд нэгдэн орсноор хүртэх ашиг шим, байгууллагын эдийн засгийг хэрхэн бэхжүүлэх талаар тусгасан байна.
- **Байгаль орчны хөгжил:** Химийн хорт бодисын менежмент, экологийн нөхөн сэргээлт, эко системийн эрүүл ахуй, экологийн шаардлага хангасан алт ба платины талаарх асуудлуудыг тусгасан байна.

2. Худалдах, боловсруулах стандарт:

- **Бүтээгдэхүүний тодорхойлолт:** Энэ хэсэгт ШО-ын стандартын шаардлага хангасныг баталгаажуулсан гэрчилгээ бүхий алт болон түүнийг дагалдах үнэт металлын тодорхойлолт, ШО-ын алт, түүнийг дагалдах үнэт металл болох мөнгө, платинаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тусгай тодорхойлолтыг багтаасан байна.
- **Цар хүрээ:** Энэ хэсэгт ШО-ын алтны хамгийн доод үнэ, урамшуулал, худалдаалах дүрэм, ашигт малтмалыг баяжуулах, цэвэршүүлэх, завсрын бүтээгдэхүүн, хайлуулах болон боловсруулах үйлдвэрлэлийн талаарх

асуудлуудыг хамруулсан. Мөн түүнчлэн олборлолтоос эхлээд эцсийн бүтээгдэхүүн хэрэглэгчид хүрэх хүртэлх Бичил уурхайн байгууллагын бүх шатны үйл ажиллагааг хамарна.

- **Гэрчилгээт үйлдвэрлэгчдээс худалдан авах:** ШО-ын гэрчилгээ бүхий байгууллага нь олборлосон хүдрээ стандартад заасны дагуу баяжуулах, үүнтэй холбоотой бүх үйл ажиллагааг ил тод, шударга хариуцлагатай, ёс суртахуунтайгаар явуулж ШО-ын гэрчилгээний цар хүрээнд боловсруулаагүй алтнаас ялгах зэрэг хариуцлагыг хүлээнэ. Тиймээс бичил уурхайн байгууллага нь ШО-ын системийн хүрээнд хэн нэгэн хүн хувьдаа эрх ашиг олохын төлөө бусдын гаргасан хичээл зүтгэлийг буруугаар ашиглахгүй байх, алтыг газар дээр нь худалдан авч цааш илүү үнээр борлуулдаг зуучлагчидтай (ченжүүд) харилцахгүй байх, бүх үйл ажиллагааныхаа гарал үүсэл, худалдаалах явцыг бүрэн ил тод, тодорхой байлгах дотоод сүлжээ, тогтолцоо үүсгэх нь чухал юм.

ОДООГИЙН БАЙДЛААР ДЭЛХИЙ ДАХИНД:

- ШО-ын гэрчилгээтэй зургаан бичил уурхайн байгууллага үйл ажиллагаа явуулж байна: Колумб Улс (3), Перу Улс (1), Болив Улс (2), Монгол Улс (1)
- 20 бичил уурхайн байгууллага гэрчилгээжүүлэлтэд хамрагдахаар бэлтгэж байна.
- 2014 оноос хойш 400 гаруй кг ШО-ын алт худалдаалагдсан.
- 1,500,000 гаруй ам.долларын нэмэлт урамшууллыг бичил уурхайн байгууллагууд хүртсэн.
- Стандартыг хэрэгжүүлснээр нийт 6,800 хүн шууд, 14,500 хүн шууд бусаар үр ашиг хүртсэн байна.

ШУДАРГА ОЛБОРЛОЛТЫН СТАНДАРТ – МОНГОЛД ХАРИУЦЛАГАТАЙГААР ОЛБОРЛОВ

2015 онд Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн дэмжлэгтэйгээр Баянхонгор аймагт бичил уурхайчид, нөхөрлөл хоршоодыг дэмжин ажилладаг Хувиараа Ашигт Малтмал Олборлогчдыг Дэмжих Холбоо (ХАМОДХ) ТББ нь Шударга Олборлолтын экологийн цэвэр алт үйлдвэрлэгч ангилалд гэрчилгээ авсан юм. ХАМОДХ ТББ нь уг стандартад нэгдэн орсноор:

- Монгол Улс уг стандартыг хэрэгжүүлэгч орнуудын нэг болж хариуцлагатай бичил уурхайн салбарт нэр хүндтэй байр суурь эзлэх болсон.
- Хамгийн өндөр шалгуур бүхий эко алт олборлогч ангилалд Азидаа анхдагч, дэлхийд 4 дүгээрт бүртгэгдсэн билээ.
- Бичил уурхайн нөхөрлөлүүдийнхээ олборлосон алтыг олон улсын зах зээлд борлуулж нэмэлт урамшуулал авах боломжтой болсон.
- Нэмэлт урамшуулал авснаар бичил уурхайчид ашиг орлогоо нэмэгдүүлэх, орон нутгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулах, нийгмийн асуудлаа шийдвэрлэх боломжтой болсон юм.
- 2016 - 2017 онуудад ХАМОДХ ТББ нь нийт 2 кг эко алт туршилтын журмаар экспортлон килограм тус бүрд нэмэлтээр 6,000 ам долларын урамшуулал авсан амжилттай ажиллаж байна.

ЗӨВ ДЭМЖЛЭГ, ХУДАЛДААНЫ УРАМШУУЛЛААР ДАМЖУУЛАН БИЧИЛ УУРХАЙН БАЙГУУЛЛАГУУД НЬ БАЙГАЛЬ ОРЧИН БОЛОН НИЙГЭМД ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТ АВЧИРНА

- **Чадавхажсан бичил уурхайчид**

ШО-ын стандартыг хэрэгжүүлснээр бичил уурхайчид хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа эрхлэх мэдлэг мэдээллээр хангагддаг. Ингэснээр тэд ажлын байртай, тогтмол орлоготой болж ядуурлаас гарах бүрэн боломжтой юм. ШО-ын нэмэлт урамшуулаар дамжуулан бичил уурхайчид суралцах, бусадтай хуваалцах болон орон нутгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулдаг.

- **Эерэг өөрчлөлт**

Уг стандартад хамрагдсанаар тухайн бичил уурхайн байгууллага нь нийгэм, байгаль орчны түвшинд тогтвортой үйл ажиллагаа явуулж эерэг өөрчлөлт авчрах чадвартай болж төлөвшдөг.

- **Бодит баталгаа**

Бичил уурхайн байгууллагууд нь хариуцлагатай, ил тод үйл ажиллагаа эрхэлдэг гэдгээ олон улсын гуравдагч аудитын байгууллагаар жил бүр баталгаажуулдаг.

ШУДАРГА ОЛБОРЛОЛТЫН СТАНДАРТЫГ ДЭМЖИГЧ, ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГУУД

ХОЛБОО БАРИХ:

Монгол Улс, Улаанбаатар хот
Скай Плаза Бизнес төв
Элчингийн гудамж 12
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

+976 11 328848
+976 11 322415

info@sam.mn
www.sam.mn, www.asmhub.mn
ASM Mongolia
ASM_Mongolia

© Энэхүү гарын авлагыг худалдахыг хориглоно.